

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/129/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНХАНГАЙ СУМЫН ХҮН ЭМНЭЛГИЙН
2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: info@dumaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.20 № 01/67
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 2022 оны 107 дугаар "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" тогтоол, Засгийн газрын 2022 оны 194 дүгээр "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор албан хаагчдын цалинд өөрчлөлт орж нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Өмнөх оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгагдаагүй албан хаагчдад олгох 2021 оны илүү цагийн урамшуулалт цалин 14,329.8 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгон зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>160,782,198.81</u>	<u>93,765,646.73</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	21,510,555.57	30,792,868.82
312	Банканд байгаа бэлэн мөнгө	21,510,555.57	30,792,868.82
3121	Төгрөг	21,510,555.57	30,792,868.82
31211	Төрийн сангийн харилцах	16,895,357.38	30,792,868.82
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	4,615,198.19	00.00
33	АВЛАГА	78,076,500.00	00.00
335	Бусад авлага	78,076,500.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	78,076,500.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	61,195,143.24	62,972,777.91
351	Түүхий эд материал	46,184,949.62	42,278,869.29
35130	Эм боох материал	46,184,949.62	42,278,869.29
354	Хангамжийн материал	15,010,193.62	20,693,908.62
35410	Бичиг хэргийн материал	223,100.00	247,500.00
35420	Аж ахуйн материал	8,740,805.00	13,460,255.00
35440	Түлш, шатах тослох материал	1,000,000.00	1,000,000.00
35460	Хүнсний материал	1,856,830.00	2,796,695.00
35470	Бусад хангамжийн материал	3,189,458.62	3,189,458.62
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>311,211,184.48</u>	<u>354,504,388.97</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	311,211,184.48	354,504,388.97
392	Биет хөрөнгө	302,563,184.48	345,856,388.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	261,695,947.69	261,695,947.69
39202	Хуримтлагдсан элэгдэл	-19,648,664.64	-26,198,219.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,540,000.00	49,540,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-32,732,000.16	-36,640,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	101,456,262.22	144,147,874.99
39206	Хуримтлагдсан элэгдэл	-63,238,486.49	-69,947,447.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,266,457.00	31,418,144.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,776,331.14	-8,159,910.96
393	Биет бус хөрөнгө	8,648,000.00	8,648,000.00
39301	Программ хангамж	850,000.00	850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-850,000.00	-850,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,648,000.00	8,648,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>471,993,383.29</u>	<u>448,270,035.70</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>19,660,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	19,660,000.00
413	Өглөг	00.00	19,660,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	19,660,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>471,993,383.29</u>	<u>428,610,035.70</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	471,993,383.29	428,610,035.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	126,542,458.80	126,542,458.80
51101	Өмч: - төрийн	126,542,458.80	126,542,458.80
512	Хуримтлагдсан үр дүн	338,455,039.05	295,071,691.46
51210	Өмнөх үеийн үр дүн	338,455,039.05	338,455,039.05
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-43,383,347.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,995,885.44	6,995,885.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>471,993,383.29</u>	<u>448,270,035.70</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	721,288,249.12	440,592,818.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	145,141,554.12	62,598,818.02
120	Нийтлэг татварын бус орлого	145,141,554.12	62,598,818.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	145,141,554.12	62,578,818.02
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	145,141,554.12	62,578,818.02
120009	Бусад орлого	00.00	20,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	247,914,795.00	377,994,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	328,231,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	144,150,755.00	250,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	144,150,755.00	250,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,643,200.00	19,293,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,643,200.00	19,293,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	84,120,840.00	358,450,100.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	84,120,840.00	358,450,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	560,338,804.37	483,976,165.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	560,338,804.37	483,976,165.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	542,458,661.83	482,223,748.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	256,218,817.45	278,746,691.65
210101	Үндсэн цалин	146,842,088.50	179,043,180.28
210102	Нэмэгдэл	82,739,464.42	76,690,703.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,213,000.00	3,540,000.00
210104	Урамшуулал	23,424,264.53	19,472,807.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,988,118.98	36,494,376.60
210201	Тэтгэврийн даатгал	24,861,243.14	26,328,276.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,640,310.90	2,541,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,111,588.73	2,033,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	527,822.20	508,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,847,154.01	5,083,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,621,207.46	17,273,840.37
210301	Гэрэл, цахилгаан	3,095,598.26	2,806,819.57
210302	Түлш, халаалт	14,315,609.20	14,147,020.80
210303	Цэвэр, бохир ус	210,000.00	320,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,504,438.00	27,244,658.00
210401	Бичиг хэрэг	1,629,350.00	2,321,700.00
210402	Тээвэр, шатахуун	15,559,188.00	15,425,608.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,366,800.00	1,497,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,691,800.00	4,542,050.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,257,300.00	3,458,000.00
2105	Норматив зардал	176,526,842.35	74,973,317.85
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	167,287,332.35	67,208,572.85

210502	Хоол, хүнс	9,239,510.00	7,764,745.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,439,850.00	2,031,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,414,850.00	2,031,300.00
2107	Томилолт, зочны зардал	259,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	259,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	14,450,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	14,450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,900,387.59	29,509,564.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,092,129.00	3,005,210.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,808,258.59	26,504,354.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,880,142.54	1,752,416.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,008,000.00	832,357.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,008,000.00	832,357.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	872,142.54	920,059.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	872,142.54	920,059.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>160,949,444.75</u>	<u>-43,383,347.59</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>160,949,444.75</u>	<u>-43,383,347.59</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	498,070,195.00	475,750,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	20,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	20,000.00
120009	Бусад орлого	00.00	20,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	498,070,195.00	475,730,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	328,231,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	144,150,755.00	250,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	144,150,755.00	250,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,643,200.00	19,293,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,643,200.00	19,293,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,044,340.00	456,186,600.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,044,340.00	456,186,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	453,732,839.43	466,468,186.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	453,732,839.43	466,468,186.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	435,852,696.89	464,715,770.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	256,218,817.45	278,746,691.65
210101	Үндсэн цалин	146,842,088.50	179,043,180.28
210102	Нэмэгдэл	82,739,464.42	76,690,703.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,213,000.00	3,540,000.00
210104	Урамшуулал	23,424,264.53	19,472,807.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,988,118.98	36,494,376.60
210201	Тэтгэврийн даатгал	24,861,243.14	26,328,276.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,640,310.90	2,541,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,111,588.73	2,033,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	527,822.20	508,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,847,154.01	5,083,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,621,207.46	17,273,840.37
210301	Гэрэл, цахилгаан	3,095,598.26	2,806,819.57
210302	Түлш, халаалт	14,315,609.20	14,147,020.80
210303	Цэвэр, бохир ус	210,000.00	320,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,333,448.00	21,644,408.00
210401	Бичиг хэрэг	1,004,050.00	2,199,100.00
210402	Тээвэр, шатахуун	14,604,798.00	15,425,608.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,495,200.00	1,497,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,229,400.00	2,522,400.00
2105	Норматив зардал	65,607,646.00	39,934,143.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	56,599,756.00	32,176,343.50
210502	Хоол, хүнс	9,007,890.00	7,757,800.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,298,150.00	50,542,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,549,500.00	24,375,000.00
210602	Тавилга	464,600.00	7,656,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	25,282,000.00	9,050,000.00
210604	Урсгал засвар	3,002,050.00	9,460,700.00
2107	Томилолт, зочны зардал	259,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	259,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	14,450,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	14,450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,526,309.00	4,129,910.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,526,309.00	4,129,910.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,880,142.54	1,752,416.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,008,000.00	832,357.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,008,000.00	832,357.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	872,142.54	920,059.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	872,142.54	920,059.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>44,337,355.57</u>	<u>9,282,313.25</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,826,800.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,826,800.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,826,800.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,826,800.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-22,826,800.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	21,510,555.57	9,282,313.25
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	21,510,555.57
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,510,555.57	30,792,868.82

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,542,458.80	6,995,885.44	338,455,039.05	471,993,383.29
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,542,458.80	6,995,885.44	338,455,039.05	471,993,383.29
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,542,458.80	6,995,885.44	338,455,039.05	471,993,383.29
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-43,383,347.59	-43,383,347.59
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,542,458.80	6,995,885.44	295,071,691.46	428,610,035.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	475,622,900.00	465,548,127.12	10,074,772.88	97.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	475,622,900.00	465,548,127.12	10,074,772.88	97.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	474,722,900.00	464,715,770.12	10,007,129.88	97.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,793,700.00	278,746,691.65	3,047,008.35	98.92
210101	Үндсэн цалин	164,142,400.00	179,043,180.28	(14,900,780.28)	109.08
210102	Нэмэгдэл	89,243,700.00	76,690,703.73	12,552,996.27	85.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,536,000.00	3,540,000.00	996,000.00	78.04
210104	Урамшуулал	23,871,600.00	19,472,807.64	4,398,792.36	81.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,976,200.00	36,494,376.60	481,823.40	98.70
210201	Тэтгэврийн даатгал	26,810,100.00	26,328,276.60	481,823.40	98.20
210202	Тэтгэмжийн даатгал	2,541,500.00	2,541,500.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,033,300.00	2,033,300.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	508,300.00	508,300.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,083,000.00	5,083,000.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,757,400.00	17,273,840.37	2,483,559.63	87.43
210301	Гэрэл, цахилгаан	4,774,900.00	2,806,819.57	1,968,080.43	58.78
210302	Түлш, халаалт	14,662,500.00	14,147,020.80	515,479.20	96.48
210303	Цэвэр, бохир ус	320,000.00	320,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,772,600.00	21,644,408.00	128,192.00	99.41
210401	Бичиг хэрэг	2,199,900.00	2,199,100.00	800.00	99.96
210402	Тээвэр, шатахуун	15,572,700.00	15,425,608.00	147,092.00	99.06
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,497,300.00	2,700.00	99.82
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	2,522,400.00	(22,400.00)	100.90
2105	Нормативт зардал	39,976,400.00	39,934,143.50	42,256.50	99.89
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,176,400.00	32,176,343.50	56.50	100.00
210502	Хоол, хүнс	7,800,000.00	7,757,800.00	42,200.00	99.46
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53,161,600.00	50,542,400.00	2,619,200.00	95.07
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,729,600.00	24,375,000.00	(1,645,400.00)	107.24
210602	Тавилга	9,870,000.00	7,656,700.00	2,213,300.00	77.58
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,050,000.00	9,050,000.00	2,000,000.00	81.90
210604	Урсгал засвар	9,512,000.00	9,460,700.00	51,300.00	99.46
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,450,000.00	14,450,000.00	-	100.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,450,000.00	14,450,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5335000.00	4129910.00	1,205,090.00	77.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,335,000.00	4,129,910.00	1,205,090.00	77.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	900000.00	832357.00	67,643.00	92.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	832,357.00	67,643.00	92.48
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	832,357.00	67,643.00	92.48
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	476,069,000.00	397,654,000.00	78,415,000.00	83.53
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	342,181,400.00	00.00	342,181,400.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	342,181,400.00	00.00	342,181,400.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	25,420,400.00	19,293,900.00	6,126,500.00	75.90
132001	Орон нутгийн төсвөөс	25,420,400.00	19,293,900.00	6,126,500.00	75.90
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	108,217,200.00	381,110,100.00	(272,892,900.00)	352.17
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	108,217,200.00	381,110,100.00	(272,892,900.00)	352.17
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	18.00	18.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	09.00	09.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	250,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	250,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	250,000.00
210402	Тээвэр, шатахуун	250,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	250,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	250,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлэг нь зорилгоо “Ажилчдын сахилга хариуцлага, хоорондын харилцааг бэхжүүлснээр эмнэлэг хүн амын хоорондын уялдааг сайжруулах, ажлын байрыг оновчтой зохион байгуулснаар анхан шатны тусламж үйлчилгээг оновчтой үзүүлэх, ажлын цагийг үр бүтээлтэй ашигласнаар иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах, эмчилгээ, үйлчилгээ, хяналтын явцыг дээшлүүлэхэд оршино” гэж тодорхойлсон.

Тус байгууллага нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сумын хүн амд чанартай, хүртээмжтэй хүргэн, эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйлчилгээ явуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”
- Засгийн газрын 2022 оны 192 дугаар тогтоол “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоол “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”
- Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49/А/118 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт “Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам”
- Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны 6 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам ”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас тус байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,723.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	21,510.55	30,792.87	9,282.32
Авлага	78,076.50	-	(78,076.50)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	61,195.14	62,972.77	1,777.63
Үндсэн хөрөнгө	311,211.18	354,504.39	43,293.21
Нийт хөрөнгийн дүн	471,993.37	448,270.03	(23,723.34)
Өглөг	-	19,660.00	19,660.00
Засгийн газрын хувь оролцоо	126,542.46	126,542.46	-
Хуримтлагдсан үр дүн	338,455.03	295,071.69	(43,383.34)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,995.88	6,995.88	-
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	471,993.37	448,270.03	(23,723.34)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт авлага, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Авлагын дансны үлдэгдэл 78,076.5 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авлагыг бүрэн барагдуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 43,293.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 31,536.7 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 38,260.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 19,660.0 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас өөр байгууллагын санхүүжилтийг данс андуурч шилжүүлснээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 342,181.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 25,420.4 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 108,217.2 мянган төгрөгийн, нийт 475,819.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 438,179.9 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 95,998.2 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 342,181.1 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант оны батлагдсан төсвийг нийт 476,069.0 мянган төгрөг буюу 8,6 хувиар нэмэгдүүлэн тодотгосон байна.

Төсвийн гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 19,293.9 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 450,398.6 мянган төгрөгийн, нийт 476,069.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 465,554.1 мянган төгрөгийг зарцуулж, 30,792.9 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 465,548.1 мянган төгрөг буюу 97,9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 3,047.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2,483.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 128.2 мянган төгрөг, норматив зардал 42.3 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 2,619.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,205.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ	475,622.90	466,468.18	9,154.72	98.08
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	-	32,203.60	(32,203.60)	-
1.2	80111-Төрийн байгууллагуудын тогтмол зардал	20,907.40	19,293.60	1,613.80	92.28
1.3	80302-Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон	174,521.10	146,430.26	28,090.84	83.90
1.4	81603-Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	167,660.30	169,640.40	(1,980.10)	101.18
1.5	83603-Нэмэлт-дээд шатны төсвөөс хуваарилсан	112,534.10	98,900.32	13,633.78	87.88
Дүн		475,622.90	466,468.18	9,154.72	98.08

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 250.0 мянган төгрөг төвлөрч, урсгалд үйл ажиллагаанд 250.0 мянган төгрөг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж, худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж байх, нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтөлж байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор Н.Тэмүүжин гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 11/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 438,179.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,572.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,929.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсран ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Батлагдсан орон тоо дутуу ажилласнаар 3,047.0 мянган төгрөгийн цалин хөлстэй холбоотой зардал, 2,483.6 мянган төгрөгийн байр ашиглалтай холбоотой тогтмол зардал, бусад тэвчиж болох бүх төрлийн зардлыг хассанаар 4,544.2 мянган төгрөг, нийт 10,074.8 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих 170 мэдээллээс 153 мэдээллийг хугацаандаа, 16 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй төлөвтэй, нийт 5,000.0 мянган төгрөгөөс дээш худалдан авалтаас 2 харилцагч байгууллагын 19,000.0 мянган төгрөгийн худалдан авалтыг шилэн дансанд мэдээлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд байршуулах мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэт, хуулийн хугацаанд багтаан мэдээлж, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 168,535.9 мянган төгрөгийн 7 асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 94,202.5 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулсан байна. Биелэлт хангалтгүй 74,333.4 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчлийг тайлант оны аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 1,058.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, 47,868.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	-	-	-	-	-
Төлбөрийн акт	1	1,058.3	1	1,058.3	100
Зөвлөмж	3	47,868.9	3	47,868.9	100
Нийт дүн	4	48,927.2	4	48,927.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 39,260.3 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 288.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 15,997.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлж, 22,974.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 288.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацаанд байгууллага сурталчлах тэмцээн уралдаан зохион байгуулж шагналд 288.0 мянган төгрөгийг зарцуулсан нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн зориулалт бусаар зарцуулсан мөнгөн хөрөнгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар 15,997.6 мянган төгрөгийн зөрчил арилгах 2 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн ариутгалын зардлыг 22.4 мянган төгрөгөөр, багаж, техник, хэрэгслийн зардлыг 1,645.4 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Өмнөх оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгагдаагүй албан хаагчдад олгох 2021 оны илүү цагийн урамшуулалт цалин 14,329.8 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан нь: Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө", НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Тасалбар болголт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн нягтлан бодох бүртгэлийг бүрэн аккрузл сууриар хөтөлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад 5 харилцагч байгууллагын 22,974.7 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх" заавартай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант хугацаанд байгууллага сурталчлах тэмцээн уралдаан зохион байгуулж шагналд 288.0 мянган төгрөгийг зарцуулсан	1	288.0	1	288.0	-	-	-	-	-	-	-	-
Тайлант хугацаанд хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн ариутгалын зардлыг 22.4 мянган төгрөгөөр, Багаж, техник, хэрэгслийн зардлыг 1,645.4 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан	1	1,667.8	-	-	1	1,667.8	-	-	-	-	-	-
Өмнөх оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгагдаагүй албан хаагчдад олгох 2021 оны илүү цагийн урамшуулалт цалин 14,329.8 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагаас олгон зарцуулсан	1	14,329.8	-	-	1	14,329.8	-	-	-	-	-	-
Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад 5 харилцагч байгууллагын 22,974.7 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй	1	22,974.7					1	22,974.7	-	-	-	-
Дүн	4	39,260.3	1	288.0	2	15,997.6	1	22,974.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<u>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</u>										
Шилэн дансанд мэдээлбэл зохих 170 мэдээллээс 153 мэдээллийг хугацаандаа, 16 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй төлөвтэй, нийт 5 сая төгрөгөөс дээш 2 харилцагч байгууллагын 19,000.0 мянган төгрөгийн худалдан авалтыг шилэн дансанд мэдээлээгүй	1	19,000.0	-	-	-	-	-	-	1	19,000.0
Дүн	1	19,000.0	-	-	-	-	-	-	1	19,000.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn